БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭМТ-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** БНА-2021/110/СТА-ТШ3


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: Tsetsegmaa_1961@yahoo.com


Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/ ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 6

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... 6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... 7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... 11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 13

3.Аудитын тайлан..... 14

3.1. Ерөнхий зүйл..... 14

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 15

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... 15

3.4. Материаллаг байдал..... 15

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 16

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... 17

3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 19

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 20

3.9. Аудитын илрүүлэлт ..... 20

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил..... 20

Аудитын зөвлөмж..... 21

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 22

Менежментийн захидал..... 22

5. Хавсралт:Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт..... 19


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт/ эх хувь/

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/70

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Г.СҮХБААТАР ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2021 А4 ТООТ

005021044

Байгууллагын удирдлага аймгийн ЭМГ, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргасан байна.

Тус байгууллага нь дэлхий нийтэд тархсан ковид-19 цар тахлын онцгой дэглэмийн үед Аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн газраас өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийгээгүй.
- Бараа материалын нярвын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс нийт дүнгээрээ 5564.1 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү буюу нийт 7251.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.
- Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А /38, А/48, А/ 168, А/174, А/133 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй олгосон 6947,2 мянга, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 974.8 мянга, нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууныг орлогод аваагүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1."жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал, Оршин байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **35,063,629.00** | **65,542,206.90** |
| **33** | **АВЛАГА** | 157,313.00 | 350,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 157,313.00 | 350,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 34,906,316.00 | 65,192,206.90 |
| **351** | **Түүхий эд материал** | 12,357,716.00 | 36,215,656.84 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,157,616.00 | 27,034,978.33 |
| 35130 | Эм боох материал | 1,200,100.00 | 9,180,678.51 |
| **354** | **Хангамжийн материал** | 22,148,600.00 | 28,976,550.06 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,101,800.00 | 1,631,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,742,800.00 | 24,248,900.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 1,367,300.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 00.06 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,235,000.00 | 1,085,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 69,000.00 | 643,850.00 |
| 35600 | Мал амьтад | 400,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **481,393,299.76** | **457,519,219.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 481,393,299.76 | 457,519,219.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 463,029,966.60 | 440,401,886.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 414,301,558.00 | 414,301,558.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -10,229,040.96 | -18,958,081.92 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61,640,000.00 | 43,640,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -33,698,888.97 | -23,525,555.61 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 110,926,859.18 | 112,926,859.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -96,208,390.90 | -101,021,880.86 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,080,105.00 | 20,180,105.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,566,701.48 | -13,190,451.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,633,000.00 | 13,633,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,918,533.27 | -7,653,666.55 |
| 39217 | Ном | 70,000.00 | 70,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,363,333.16 | 17,117,333.32 |
| 39301 | Программ хангамж | 650,000.00 | 650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -626,666.84 | -650,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,340,000.00 | 18,340,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -1,222,666.68 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **516,456,928.76** | **523,061,426.28** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,458,029.81** | **1,963,648.90** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,458,029.81 | 1,963,648.90 |
| **413** | **Өглөг** | 1,458,029.81 | 1,963,648.90 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 889,959.81 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 568,070.00 | 1,963,648.90 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 568,070.00 | 1,963,648.90 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **514,998,898.95** | **521,097,777.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 514,998,898.95 | 521,097,777.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 580,017,310.00 | 580,017,310.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 580,017,310.00 | 580,017,310.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -133,937,020.60 | -127,838,142.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -133,937,020.60 | -133,937,020.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 6,098,878.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 68,918,609.55 | 68,918,609.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **516,456,928.76** | **523,061,426.28** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **388,377,640.00** | **418,660,127.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,505,000.00** | **21,291,777.23** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,505,000.00 | 21,291,777.23 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,505,000.00 | 21,291,777.23 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 10,505,000.00 | 21,291,777.23 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **377,872,640.00** | **397,368,350.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 339,794,800.00 | 354,536,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 339,794,800.00 | 354,536,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,700.00 | 4,345,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,700.00 | 4,345,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,597,800.00 | 21,137,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,597,800.00 | 21,137,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 17,440,340.00 | 17,349,050.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,440,340.00 | 17,349,050.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **389,177,280.83** | **412,561,248.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **389,177,280.83** | **412,561,248.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 389,137,451.91 | 412,533,404.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 241,317,389.00 | 271,723,056.09 |
| 210101 | Үндсэн цалин | 205,030,978.00 | 222,538,808.09 |
| 210102 | Нэмэгдэл | 19,294,687.00 | 39,733,931.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 16,991,724.00 | 9,450,317.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,635,787.22 | 35,386,265.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,926,797.93 | 24,316,723.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,317,763.89 | 2,827,274.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,608,520.96 | 2,261,821.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 861,226.50 | 543,677.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,921,477.94 | 5,436,770.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,909,635.65 | 19,897,972.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,716,835.00 | 2,775,573.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,192,800.65 | 17,087,399.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 35,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,596,091.80 | 29,012,391.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,719,900.00 | 1,190,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,586,041.80 | 23,515,841.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,297,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,800.00 | 45,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,882,550.00 | 2,963,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,148,024.30 | 20,108,451.39 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,962,128.30 | 14,117,261.39 |
| 210502 | Хоол, хүнс | 8,185,896.00 | 5,991,190.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,617,000.00 | 859,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,617,000.00 | 859,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 892,000.00 | 1,070,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 892,000.00 | 1,070,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,990,868.00 | 6,699,088.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,990,868.00 | 6,299,088.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,030,655.94 | 27,777,080.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,151,000.00 | 803,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,879,655.94 | 26,974,080.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,828.92 | 27,844.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,700.00 | 6,962.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,700.00 | 6,562.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 400.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 128.92 | 20,882.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 128.92 | 20,882.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-799,640.83** | **6,098,878.43** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 21,508,812.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21,508,812.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -21,508,812.00 | 00.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-22,308,452.83** | **6,098,878.43** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **377,872,640.00** | **397,368,350.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **377,872,640.00** | **397,368,350.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 339,794,800.00 | 354,536,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 339,794,800.00 | 354,536,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,700.00 | 4,345,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,700.00 | 4,345,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,597,800.00 | 21,137,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,597,800.00 | 21,137,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 17,440,340.00 | 17,349,050.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,440,340.00 | 17,349,050.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **377,872,640.00** | **395,848,350.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **377,872,640.00** | **395,848,350.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **377,832,811.08** | **395,820,506.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 244,351,299.98 | 265,787,125.00 |
| 210101 | Үндсэн цалин | 183,731,400.00 | 188,431,572.93 |
| 210102 | Нэмэгдэл | 47,136,218.98 | 62,893,549.52 |
| 210104 | Урамшуулал | 13,483,681.00 | 14,462,002.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,543,900.00 | 36,712,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,769,900.00 | 25,741,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,443,501.00 | 2,742,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,954,800.00 | 2,194,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 488,699.00 | 548,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,887,000.00 | 5,485,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,597,800.00 | 20,131,338.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,716,835.00 | 2,775,573.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,670,615.00 | 17,182,865.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 210,350.00 | 172,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,406,991.80 | 26,827,141.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,432,450.00 | 1,200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,586,041.80 | 21,055,741.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,682,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,081,700.00 | 1,938,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,796,503.30 | 18,059,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,162,228.30 | 9,041,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,124,275.00 | 6,298,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,510,000.00 | 2,718,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,460,000.00 | 2,956,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,060,000.00 | 1,957,000.00 |
| 210602 | Тавилга | 1,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 999,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 892,000.00 | 1,070,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 892,000.00 | 1,070,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,099,307.00 | 15,066,112.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,099,307.00 | 14,666,112.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,685,009.00 | 9,210,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,685,009.00 | 9,210,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,828.92** | **27,844.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,700.00 | 6,962.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,700.00 | 6,562.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 400.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 128.92 | 20,882.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 128.92 | 20,882.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **1,520,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **1,520,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **1,520,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 1,520,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 1,520,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-1,520,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 561,677,310.00 | 59,739,971.00 | -70,918,791.85 | 00.00 | 550,498,489.15 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **561,677,310.00** | **59,739,971.00** | **-70,918,791.85** | **00.00** | 550,498,489.15 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -40,805,775.91 | 00.00 | -40,805,775.91 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **-133,937,020.60** | **00.00** | 514,998,898.95 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **-133,937,020.60** | **00.00** | 514,998,898.95 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **-133,937,020.60** | **00.00** | 514,998,898.95 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 6,098,878.43 | 00.00 | 6,098,878.43 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **-127,838,142.17** | **00.00** | 521,097,777.38 |

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилт-гах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 397,859,100.00 | 392,995,506.00 | -4,863,594.00 | 98.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 397,859,100.00 | 392,995,506.00 | -4,863,594.00 | 98.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 397,859,100.00 | 392,995,506.00 | -4,863,594.00 | 98.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 271,041,700.00 | 265,787,125.00 | -5,254,575.00 | 98.1 |
| 210101 | Үндсэн цалин | 191,089,200.00 | 188,431,572.93 | -2,657,627.07 | 98.6 |
| 210102 | Нэмэгдэл | 64,062,300.00 | 62,893,549.52 | -1,168,750.48 | 98.2 |
| 210104 | Урамшуулал | 15,890,200.00 | 14,462,002.55 | -1,428,197.45 | 91.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,712,100.00 | 36,712,000.00 | -100.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,741,700.00 | 25,741,700.00 | 00.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,742,600.00 | 2,742,100.00 | -500.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,194,100.00 | 2,194,500.00 | 400.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 548,500.00 | 548,600.00 | 100.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,485,200.00 | 5,485,100.00 | -100.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,137,800.00 | 20,131,338.00 | -6,462.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,823,000.00 | 2,775,573.00 | -47,427.00 | 98.3 |
| 210302 | Түлш, халаалт | 17,084,900.00 | 17,182,865.00 | 97,965.00 | 100.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 229,900.00 | 172,900.00 | -57,000.00 | 75.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,969,300.00 | 26,827,141.00 | -142,159.00 | 99.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,200,000.00 | 00.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,132,500.00 | 21,055,741.00 | -76,759.00 | 99.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,686,800.00 | 1,682,900.00 | -3,900.00 | 99.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 1,938,500.00 | -61,500.00 | 96.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 950,000.00 | 00.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,060,700.00 | 18,059,490.00 | -1,210.00 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,041,900.00 | 9,041,900.00 | 00.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,298,790.00 | -1,210.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,718,800.00 | 2,718,800.00 | 00.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,200,000.00 | 2,956,900.00 | -243,100.00 | 92.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,200,000.00 | 1,957,000.00 | -243,000.00 | 89.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 999,900.00 | -100.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,131,700.00 | 1,070,000.00 | -61,700.00 | 94.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,131,700.00 | 1,070,000.00 | -61,700.00 | 94.5 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,721,200.00 | 10,721,112.00 | -88.00 | 100.0 |
| 210801 | БГАҮ-ний төлбөр хураамж | 10,321,200.00 | 10,321,112.00 | -88.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 | 00.00 | 100.0 |
| **2109** | **Бара а үйлчилгээний бусад зардал** | 9884600.00 | 10730400.00 | 845,800.00 | 108.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,884,600.00 | 10,730,400.00 | 845,800.00 | 108.6 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 397,859,100.00 | 392,995,506.00 | -4,863,594.00 | 98.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 354,536,100.00 | 354,508,656.00 | -27,444.00 | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 354,536,100.00 | 354,508,656.00 | -27,444.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 21,137,800.00 | 21,137,800.00 | 00.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 21,137,800.00 | 21,137,800.00 | 00.00 | 100.0 |
| **1340** | **НДС-ийн төсвөөс ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,185,200.00 | 17,349,050.00 | -4,836,150.00 | 78.2 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,185,200.00 | 17,349,050.00 | -4,836,150.00 | 78.2 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 26.00 | 01.00 | 104.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08.00 | 09.00 | 01.00 | 112.5 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **27.00** | **27.00** | 00.00 | 100.0 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 18.00 | 18.00 | 00.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 05.00 | 06.00 | 01.00 | 120.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 04.00 | 03.00 | -01.00 | 75.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **4,345,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **4,345,400.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 4345400.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | 4,345,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 4,345,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 4,345,400.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 4345400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 4,345,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 345,400.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 21–ны хооронд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл амьдрах нөхцөлийг буй болгож , эрүүл мэндийн салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл таатай орчин бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 412561.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8251.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 523061.4 мянган төгрөг болж өмнөх оноос 6604.5 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 35,063.6 | 65,542.2 | 30,478.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 157.3 | 350.0 | 192.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 34,906.3 | 65,192.2 | 30,285.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 481,393.3 | 457,519.2 | (23,874.1) |
| Үндсэн хөрөнгө | 638,641.5 | 623,741.5 | (14,900.0) |
| Хуримтлагдсан элэгдэл | (157,248.2) | (166,222.3) | (8,974.1) |
| **Нийт хөрөнгө** | 516,456.9 | 523,061.4 | 6,604.5 |
| Өр төлбөр | 1,458.0 | 1,963.6 | 505.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 514,998.9 | 521,097.8 | 6,098.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 516,456.9 | 523,061.4 | 6,604.5 |

Авлага дансны өмнөх оны үлдэгдэл 157.3 мянган төгрөгөөс 7.3 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд урьдчилгаа цалингийн суутгаагүй 200.0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65192.2 мянган төгрөг болж 30285.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой ЭМГ-аас 7530.9 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл , хамгаалах хэрэгслийг үнэ төлбөргүй олгосон, эмийн үлдэгдэл оны эхэнд 1200.1 мянган төгрөг байсан ба тайлант онд үнэ төлбөргүйгээр ЭМГ-аас тендерийн 12960.8 мянган төгрөгийн эмийг олгосон, төсвийн хөрөнгөөр 9137.0 мянган төгрөгийн худалдан авалт хийснээр эцсийн үлдэгдэл 9180.6 мянган төгрөг болж 7980.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн төсвийн хөрөнгөөр 8346.4 мянган төгрөгийн хамгаалах хэрэгсэл, бусад тусгай зориулалтын материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 623741.5 мянган төгрөг болж 14900,0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч , 2011 онд ашиглалтад орсон 18000.0 мянган төгрөгийн үнэтэй УАЗ 469 машиныг данснаас хассан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 17113.7 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 521097.8 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 6098.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 418660.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 30282.5 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого мянга 10786.8 мянган төгрөгөөр өссөн, тусгай зориулалтын шилжүүлгээр авах санхүүжилт 14741.3 мянга, орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилт 540.0 мянган төгрөгөөр төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 354536.1 мянган , орон нутгийн төсвөөс 21137.8 мянган, ЭМД-аас 17349.0 мянган төгрөгийн, нийт 393022.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 4345.0 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрснийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Батлагдсан төсөвт нийт зардал 397859.1 мянган төгрөг болж өмнөх оноос 125528.0 мянган төгрөгөөр буюу 45.9 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой цалин , НДШ-ийн зардал 113917.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд аудит хийхэд системийн дээд байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний статистик тоон мэдээллийг ЭМЯ-д хүргүүлж түүнд үндэслэн төсвийн төсвийг боловсруулдаг тул байгууллагаар төсвийн төсөл боловсруулдаггүй гэсэн тайлбарыг аймгийн ЭМГ-ын төсвийн мэргэжилтэн н.Гэрэлчулуун өгсөн бөгөөд тухайн байгууллага дээр төсвийн төсөл нэгтгэсэн дүнгээр боловсруулаагүй байна. 2019 оны шилэн дансны мэдээллээс авч үзэхэд төсвийн төсөл дараах байдалтай байна.

Үүнд:

Шилэн дансанд тавигдсан төсвийн төсвийн мэдээлэл.

| Д.Д | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Төслөөрхи дүн | Батлагдсан дүн | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалингийн зардал | Мян.төгрөг | 314185.0 | 271041.7 | -43143.3 |
| 2 | Гэрэл цахилгаан | Мян.төгрөг | 2351.2 | 2823.6 | 472.4 |
| 3 | Түлш халаалт | Мян.төгрөг | 20160.0 | 17084.9 | -3075.1 |
| 4 | Цэвэр бохир ус | Мян.төгрөг | 40.0 | 229.9 | 189.9 |
| 5 | Урсгал засвар | Мян.төгрөг | 9890.0 | 1000.0 | -8890.0 |
| 6 | Сэлбэг хэрэгсэл | Мян.төгрөг | 8520.0 | 3200.0 | -5320.0 |
| 7 | Тавилга эд хогшил | Мян.төгрөг | 11600.0 | | -11600.0 |
| | **ДҮН** | | **366746.2** | **295379.7** | **-71366.5** |

*Эх сурвалж: Шилэн дансны сайтад 2019 онд байршуулсан дараа жилийн төсвийн төсөл мэдээллээс авав.*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн захирагчийн хүргүүлсэн 7 төрлийн 366746.7 мянган төгрөгийн зардлын төсвийн төслөөс дүнгээрээ 71366.5 мянган төгрөг хасагдаж батлагдсан бөгөөд бусад зардлын хувьд статистик тоон мэдээлэлд үндэслэн ЭМЯ төсвийг боловсруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1."Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьялагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьялах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 397859.1 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 354536.1 мянган төгрөгийн , орон нутгийн төсвөөс 21137.8 мянган төгрөгийн, ЭМД-аас 22185.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан төсвийн санхүүжилтээс ЭМД-аас авах санхүүжилтийг 4836.1 мянган төгрөгөөр дутуу авч, урсгал үйл ажиллагаанд 395995.5 мянган төгрөгийг зарцуулж 27.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. ЭМД-ын санхүүжилтийг дутуу авснаар гарсан тооцоо нь СТСХ-ээс ирүүлсэн төсвийн хуваариар тавигдсан дүн бөгөөд төсвийн хэлбэлзлээр нэг иргэнээр тооцсон нормативт зардлын төлөвлөгөө 2645.3 мянган төгрөгөөр хасагдсан байгаа болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 395995.5 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 5254.5 төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой боловч ЭМД-ын санхүүжилтийг дутуу авснаас ажилтнуудын үр дүнгийн урамшууллыг бага хувиар олгосон гэсэн тайлбар өгч байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 81603 буюу үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ арга хэмжээний цалингийн зардал 2657.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 2 – ТГ-бүлэгтэй тайлан

Мянган төгрөгөөр

| Нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ХӨТӨЛБӨР 71602:Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | 0 | 0 | 0 | |
| **1.АРГА ХЭМЖЭЭ 80109- тогтмол зардал** | **0** | **0** | **0** | |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **21137.8** | **21131.2** | **6.5** | 100.0 |
| Төсвөөс санхүүжих | -21,137.8 | -21,137.8 | 0.0 | 100.0 |
| Гэрэл, цахилгаан | 2,823.0 | 2,775.6 | 47.4 | 98.3 |
| Түлш, халаалт | 17,084.9 | 17,182.9 | -98.0 | 100.6 |
| Цэвэр, бохир ус | 229.9 | 172.9 | 57.0 | 75.2 |
| Урсгал засвар | 1,000.0 | 999.9 | 0.1 | 100.0 |
| **2.АРГА ХЭМЖЭЭ -80302 нэг иргэнд ногдох нормативт зардал** | **0** | **0** | **0** | |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **17259.5** | **15217.0** | **2042.5** | 88.5 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | -2,645.3 | 0.0 | -2,645.3 | 0.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн | -14,614.2 | -15,217.0 | 602.8 | 104.1 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,129.6 | 2,129.6 | 0.0 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,200.0 | 1,957.0 | 243.0 | 89.0 |
| Аудит бат, зэрэглэл тогтоох | 400.0 | 400.0 | 0.0 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,529.9 | 10,730.4 | 1,799.5 | 85.6 |
| **3.АРГА ХЭМЖЭЭ 81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ** | **0.0** | **0.0** | **0.0** | |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **362,107.1** | **357250.0** | **4857.1** | |
| Хандив тусламж-дотоод | -22,185.2 | -17,349.1 | -4,836.2 | 78.2 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн | -339,921.9 | -339,319.1 | -602.8 | 99.8 |
| Үндсэн цалин | 191,089.2 | 188,431.6 | 2,657.6 | 98.6 |
| Нэмэгдэл | 64,062.3 | 62,893.5 | 1,168.8 | 98.2 |
| Урамшуулал | 15,890.2 | 14,462.0 | 1,428.2 | 91.0 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 25,741.7 | 25,741.7 | 0.0 | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 2,742.6 | 2,742.1 | 0.5 | 100.0 |
| ҮОМШ-ний даатгал | 2,194.1 | 2,194.5 | -0.4 | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 548.5 | 548.6 | -0.1 | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,485.2 | 5,485.1 | 0.1 | 100.0 |
| Бичиг хэрэг | 1,200.0 | 1,200.0 | 0.0 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 21,132.5 | 21,055.7 | 76.8 | 99.6 |
| Шуудан, холбоо, интернэт | 1,686.8 | 1,682.9 | 3.9 | 99.8 |
| Хог хаягдал зайлуулах, хортон | 2,000.0 | 1,938.5 | 61.5 | 96.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 950.0 | 950.0 | 0.0 | 100.0 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,912.3 | 6,912.3 | 0.0 | 100.0 |
| Хоол, хүнс | 6,300.0 | 6,298.8 | 1.2 | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,718.8 | 2,718.8 | 0.0 | 100.0 |
| Дотоод албан томилолт | 1,131.7 | 1,070.0 | 61.7 | 94.5 |
| Бусад нийтлэг АҮТХураамж | 10,321.2 | 10,321.1 | 0.1 | 100.0 |

***Жич:Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзэлтэй тайланг төсвийн хэлбэлзлээр гаргав. СТСХ-ээс ирүүлсэн төлөвлөгөөнөөс 80302 арга хэмжээний бусад бараа үйлчилгээний зардал 2635.3 мянган төгрөгөөр дутуу байгаа болно***

Төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн 4345.4 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж холбогдох дансаар тайлагнасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 5 | 36 | 31 | 5 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 82 | 14 | |
| | | 29 | 151 | 128 | 21 | 2 |

Шилэн дансны сайтад сар, улирал , жил, тухай бүр оруулах нийт 29 төрлийн давхардсан тоогоор 151 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд сар бүр байршуулах 3 төрлийн 5, тухай бүр байршуулах 5 төрлийн 14 , бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2, нийт 10 төрлийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитын зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30969.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч ,2038.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17833.9 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 11096.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах , дахин давтахгүй байх 4 заалт бүхий зөвлөмж өгөв.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар :

1. НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг анхан шатны баримт, МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад нийт дүнгээрээ бараа материалын нярвын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс 5564.1 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү буюу нийт 7251.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсаныг анхан шатны баримтыг үндэслэн залруулга хийлгэсэн.

2.Тусламж хандивын орлогыг бүрэн тусгасан эсэхийг ЭМГ-аас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгахад ЭМГ-ын даргын 2020.01.08-ны өдрийн А/48 тоот тушаалаар ЭМ-ийн байгууллагуудад ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 974.8 мянган, 2020.12.31-ний А/174 тоот тушаалаар хуваарилсан 714.2 мянга, 2020.11.20-ний А/133 тоот тушаалаар хуваарилсан 5404.2 мянган, 2020.12.25-ны А/ 168 тоот тушаалаар хуваарилсан 800, 0 мянган, 2020.04.21-ний А/38 тоот тушаалаар хуваарилсан 99.1 мянган, нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууныг орлогод аваагүй алдаа илэрч, орлогод авхуулж санхүүгийн тайланд залруулсан.

3. Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тооллогын бүртгэл байхгүй бөгөөд тус байгууллага нь тооллого хийгээгүй байна. Энэ нь төсвийн захирагчийн 2020 онд гаргасан тушаалын товьёгоос үзэхэд тооллогын комисс томилсон тушаал гараагүй байна. Горим сорил гүйцэтгэх явцад 1580.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд орлогодсон алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:

12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;..гэснийг зөрчсөн.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. Тайлант хугацаанд 2019 онд худалдан авсан 8 нэрийн 5150.0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл бодоогүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

5.Өглөг , авлагын үлдэгдлийг Татварын хэлтэс, НДХ-тэй тооцоо хийж үзэхэд ХХОАТ-ын өмнөх онд илүү төлсөн 1614.1 мянган төгрөг, авто тээврийн хэрэгслийн татварын илүү төлөлт 124.6 мянган төгрөг, тайлант онд 28-31 дугаартай автомашины татварыг 3 удаа буюу 97.8 мянган төгрөгийг илүү төлж , тайлант оны ногдуулалтын тооцоогоор суутган татварын 1816.0 мянган, тээврийн хэрэгслийн татварын 222.4 мянган, нийт 2038.4 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй тул төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

1. Хөрөнгийн дахин үнэлгээний бичилт зөв эсэхийг СТ-д тусгасан дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 68918.6 мянган төгрөгөөр ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 9178.6 мянган төгрөгөөр, ОНӨГ-ын нэгтгэл тайланд -7640.7 мянган төгрөгөөр тус тус тусгагдсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 4.44 дэх заалттай нийцэхгүй байна.

2.Санхүүгийн тайланд тусгагдсанаар хүнсний 643.8 мянган төгрөгийн, эмийн 9180.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эмийн үлдэгдэл оны эхэнд 1200.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9137.0 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон тендерийн эм 12960.8 мянган төгрөг буюу нийт орлого 22097.8 мянган төгрөг, үүнээс зарцуулсан нь 14117.3 мянган төгрөг, үлдэгдэл 9180.7 мянган төгрөг байгаа нь тухайн жилийн зарцуулсан төсөвтэй харьцуулж үзэхэд 8 орчим сарын хэрэглээний эм нөөцөлсөн байна. Эмийн үлдэгдэлд аймгийн ЭМГ-аас тендерийн нэрээр олгож буй эм ч нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэнтэй нийцэхгүй байна.

3. Шилэн дансны сайтад сар, улирал , жил, тухай бүр оруулах нийт 29 төрлийн давхардсан тоогоор 151 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд сар бүр байршуулах 3 төрлийн 5, тухай бүр байршуулах 5 төрлийн 14 , бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2, нийт 10 төрлийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4. ЭМД-аас 22185.2 мянган төгрөгийг авах төлөвлөгөөтэй боловч гүйцэтгэлээр 721 хүнтэй холбоотой 18258.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар нэхэмжилснээс 949.2 мянган төгрөг нь хасагдаж 17309.1 мянган төгрөгийг авсан байна. Тайлант оны эмийн батлагдсан төсөв 9041.9 мянган төгрөг, батлагдсан төсөвт багтаан эмийн худалдан авалтыг хийсэн байхад эмийн 1916.1 мянган төгрөгийн эмийн өртэй гарсан .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэнтэй нийцэхгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал :

- Шатахууны тооцоо бодолтын байдал, нярвын тайлан гаргалтад анхаарал хандуулах.

-Аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр нэг удаагийн амны хаалт, нэг удаагийн бээлий, комбинзон, нүдний шил зэрэг эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл олгож хангалттай нөөц бүрдүүлсэн байхад “ЮУ БИ ЛАБ” ХХК-иас худалдан авалт хийж өглөг үүсгэсэн асуудалд дараагийн аудитаар анхаарал хандуулах

- Хөрөнгийн тооллого хийгээгүй асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

**Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

***1.1.Илрүүлэлт:*** Хөрөнгийн дахин үнэлгээний бичилт зөв эсэхийг Санхүүгийн тайланд тусгасан дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 68918.6 мянган төгрөгөөр бүртгэлтэй байхад ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 9178.6 мянган төгрөгөөр, ОНӨГ-ын нэгтгэл тайланд -7640.7 мянган төгрөгөөр тус тус тусгагдсан байна.

***1.2. Эрсдэл:*** *Хөрөнгийн үнэ зөрүүтэй илэрхийлэгдэх*

***1.3 Өгсөн зөвлөмж:*** Аймгийн ОНӨГ-т хандаж 2012 он, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангуудаас тулгалт хийн дахин үнэлгээний зөрүү дансыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, түүнд нийцүүлэн гаргасан зааврын дагуу залруулгыг хийх

***1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:****Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2.1.Илрүүлэлт:*** Санхүүгийн тайланд тусгагдсанаар хүнсний 643.8 мянган төгрөгийн, эмийн 9180.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эмийн үлдэгдэл оны эхэнд 1200.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9137.0 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон тендерийн эм 12960.8 мянган төгрөг буюу нийт орлого 22097.8 мянган төгрөг, үүнээс зарцуулсан нь 14117.3 мянган төгрөг, үлдэгдэл 9180.7 мянган төгрөг байгаа нь тухайн жилийн зарцуулсан төсөвтэй харьцуулж үзэхэд 8 орчим сарын хэрэглээний эм нөөцөлсөн байна.

***2.2. Эрсдэл:*** *Хэрэгцээнээс их хэмжээний эм нөөцөлснөөс эмийн хугацаа дуусах, чанар байдал алдагдах зэргээр төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах*

***2.3. Өгсөн зөвлөмж:*** *Эмийн үлдэгдэлд тооллого хийж, үлдэгдэл эмийг аймгийн ЭМГ-т хүсэлт тавьж, шаардлагатай эмээр солилцоо хийх зэрэг арга хэмжээ авч төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, цаашид батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулж, хэрэгцээнээс их хэмжээгээр эм , эмнэлгийн хэрэгсэл авч нөөцөлдгийг зогсоох*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

***2.4.. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>:****Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***3.1. <u>Илрүүлэлт</u>:*** Шилэн дансны сайтад сар, улирал , жил, тухай бүр оруулах нийт 29 төрлийн давхардсан тоогоор 151 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд сар бүр байршуулах 3 төрлийн 5, тухай бүр байршуулах 5 төрлийн 14 , бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2, нийт 10 төрлийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

***3.2. <u>Эрсдэл</u>:*** *Хууль хэрэгжихгүй байх*

***3.3 <u>Өгсөн зөвлөмж</u>:*** *Шилэн дансны мэдээллийн сайтад байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах*

***3.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>:****Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***4.1. <u>Илрүүлэлт</u>:*** *ЭМД-аас 22185.2 мянган төгрөгийг авах төлөвлөгөөтэй болович гүйцэтгэлээр 721 хүнтэй холбоотой 18258.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар нэхэмжилснээс 949.2 мянган төгрөг нь хасагдаж 17309.1 мянган төгрөгийг авсан байна. Тайлант оны эмийн батлагдсан төсөв 9041.9 мянган төгрөг, батлагдсан төсөвт багтаан эмийн худалдан авалтыг хийсэн байхад эмийн 1916.1 мянган төгрөгийн эмийн өртэй гарсан .*

***4.2. <u>Эрсдэл</u>:*** *Төсвийн тухай хууль зөрчих*

***4.3. <u>Өгсөн зөвлөмж</u>:*** *Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулах, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж өглөгийг барагдуулах, өр, авлагагүй ажиллах*

***4.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>****Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА
Огноо: 2021.02.20

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.20

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.20

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт :Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/110/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЭМТ | Мянган төгрөг |
| | | | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг анхан шатны баримт, МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад нийт дүнгээрээ бараа материалын нярвын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс 5564.1 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү буюу нийт 7251.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан | 7251.9 | Санхүүгийн тайланд залруулсан | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 2 | Тусламж хандивын орлогыг бүрэн тусгасан эсэхийг ЭМГ-аас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгахад ЭМГ-ын даргын 2020.01.08-ны өдрийн А/48 тоот тушаалаар ЭМ-ийн байгууллагуудад ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 974.8 мянган, 2020.12.31-ний А/174 тоот тушаалаар хуваарилсан 5404.2 мянган, 2020.12.25-ны А/ 168 тоот тушаалаар хуваарилсан 800, 0 мянган, 2020.04.21-ний А /38 тоот тушаалаар хуваарилсан 99.1 мянган, нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууны орлогод аваагүй | 7922.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 3 | Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тооллогын бүртгэл байхгүй бөгөөд тус байгууллага нь тооллого хийгээгүй ньтөсвийн захирагчийн 2020 онд гаргасан тушаалын товьёгоос үзэхэд тооллогын комисс томилсон тушаал гараагүй | 1580.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Дарга, нягтла | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байна. Горим сорил гүйцэтгэх явцад 1580.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд орлогодсон | | | н бодогч | |
| 4 | Өглөг , авлагын үлдэгдлийг Татварын хэлтэс, НДХ-тэй тооцоо хийж үзэхэд ХХОАТ-ын өмнөх онд илүү төлсөн 1614.1 мянган төгрөг, авто тээврийн хэрэгслийн татварын илүү төлөлт 124.6 мянган төгрөг, тайлант онд 28-31 дугаартай автомашины татварыг 3 удаа буюу 97.8 мянган төгрөгийг илүү төлж нийт 2038.4 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй | 2038.4 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 5 | Тайлант хугацаанд 2019 онд худалдан авсан 8 нэрийн 5150.0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл бодоогүй алдааг санхүүгийн тайланд залруулсан | 1030.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 6 | Хөрөнгийн дахин үнэлгээний бичилт зөв эсэхийг Санхүүгийн тайланд тусгасан дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 68918.6 мянган төгрөгөөр бүртгэлтэй байхад ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 9178.6 мянган төгрөгөөр, ОНӨГ-ын нэгтгэл тайланд -7640.7 мянган төгрөгөөр тус тус тусгагдсан байна. | 0.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 7 | Санхүүгийн тайланд тусгагдсанаар хүнсний 643.8 мянган төгрөгийн, эмийн 9180.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эмийн үлдэгдэл оны эхэнд 1200.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9137.0 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон тендерийн эм 12960.8 мянган төгрөг буюу нийт орлого 22097.8 мянган төгрөг, үүнээс зарцуулсан нь 14117.3 мянган төгрөг, үлдэгдэл 9180.7 мянган төгрөг байгаа нь тухайн жилийн зарцуулсан төсөвтэй харьцуулж үзэхэд 8 орчим сарын хэрэглээний эм нөөцөлсөн байна. | 9180.7 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Шилэн дансны сайтад сар, улирал , жил, тухай бүр оруулах нийт 29 төрлийн давхардсан тоогоор 151 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд сар бүр байршуулах 3 төрлийн 5, тухай бүр байршуулах 5 төрлийн 14 , бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2, нийт 10 төрлийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 0.00 | Зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| 9 | Тайлант оны эмийн батлагдсан төсөв 9041.9 мянган төгрөг, батлагдсан төсөвт багтаан эмийн худалдан авалтыг хийсэн байхад эмийн 1916.1 мянган төгрөгийн эмийн өртэй гарсан байна. | 1916.1 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Г.Сүхбаатар, М.Эрдэнэтуяа, |
| **ДҮН** | | **30969.1** | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ